

**ХОВД ХОТЫН УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ,  
ДӨРГӨНИЙ УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫГ ХАМГААЛАХ  
ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУСГАЙ САЛАА**

/2019 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРАЛ ТОВЧ ТАЙЛАН/

**Нэг. АЛБА, АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**А/ Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн чиглэлээр:**

Цагдаагийн Ерөнхий газар, Дотоодын цэргийн штабаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг бүрэн хэрэгжүүлэн, ажлын тайлан мэдээ тогтоосон хугацаанд нь гарган Дотоодын цэргийн штабт хүргүүлж, улсын онц чухал объектын хамгаалалтыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулсан.

“Дөргөн усан цахилгаан станц” ХХК, “Шим-Ус” ОНӨААТҮГ-тай 2018 онд байгуулсан “Хамгаалалтын гэрээ”-ний биелэлтийг дүгнэж, эрсдлийн үнэлгээ гаргасан. Тусгай салааны алба хаагчид 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тусгай салааны алба хаагчдын ажлыг шалгуур үзүүлэлтээр сар бүр дүгнэж, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

**Б/Албаны сургалт бэлтгэл, цэргийн албаны зохион байгуулалтын чиглэлээр:**

Дотоодын цэргийн тусгай салааны албаны сургалтыг Дотоодын цэргийн штабын даргын батласан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу тусгай салааны офицер, ахлагч нарт албаны сургалт, дадлагыг зохион байгуулж сургалтын нэгдсэн мэдээ, танилцуулгыг Дотоодын цэргийн штабт хүргүүлсэн.

Энэ улиралд цагдаагийн газраас зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн сургалтанд тусгай салааны алба хаагчид тухай бүр нь бүрэн хамрагдсан.

**В/Сахилга ёс зүй, соёл хүмүүжлийн ажлын чиглэлээр:**

Өнгөрсөн улиралд тусгай салааны алба хаагчдаас ажил албан үүргээ сайн гүйцэтгэсэн 2 алба хаагч сарын ажлын үр дүнгээр сарын үндсэн цалинг нэг сар 10 хувь нэмж сайшаагдаж, хариуцсан ажил албандаа хариуцлагагүй хандсан, өгсөн үүрэг тушаал хангалтгүй биелүүлсэн 5 алба хаагч сарын ажлын үр дүнгээр сарын үндсэн цалинг нэг сар 10-15 хувь хасах арга хэмжээ тооцуулсан. Бусад алба хаагчдаас сахилга, хариуцлга, ёс зүйн зөрчил дутагдал гаргаагүй үүргээ хэвийн гүйцэтгэсэн.

Замын цагдаагийн тасгаас зохион байгуулсан “АХА” асуулт хариултын тэмцээн, “Сээр хугалах” тэмцээнд салааны алба хаагчид амжилттай оролцсон.

Монголын уламжлалт “Сар шинэ”-ийн баярыг угтсан “Дээлтэй монгол” арга хэмжээ тусгай салааны алба хаагчид бүрэн хамрагдсан.

Салааны хэмжээнд 2019 оны 03 дугаар сарын 08-ний өдөр алба хаагчдын гэр бүл болон ээжүүдэд “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн баярын мэнд хүргэж захидал илгээж мэндчилгээ дэвшүүлэх гэр бүлээ баярлуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.

Монгол цэргийн өдөр буюу Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг угтаж Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгуулагуудын дунд явагдсан “Марш-тактик”, “Гар бөмбөг”, “Сагсан бөмбөг” бусад тэмцээнд нэр бүхий алба хаагчид амжилттай оролцсон.

Лхагва гараг бүр спортын арга хэмжээнд тусгай салааны алба хаагчид хамрагдаж байна.

### **Г/Хангалт үйлчилгээ, зэвсэг хэрэглэлийн чиглэлээр**

Улсын онц чухал объектын хамгаалалтад ашиглагдаж байгаа албаны зэвсэг галт хэрэглэл, тусгай хэрэгсэл, харуулын цэгийн эд хогшлийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд томилгоот харуулын дарга нараар тогтмол үзлэг шалгалт хийлгүүлж, бүртгэлээр тулгалт хийн хүлээлцүүлж хяналт тавин холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна. Одоогоор илэрсэн ямар нэгэн зөрчил дутагдал байхгүй.

## **Хоёр.ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

### **А/Улсын онц чухал объектын хамгаалалтын талаар**

Тус салаа нь Улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд хэвийн зохион байгуулан удирдаж хамгаалалтад үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоог амралт ачааллыг нь тэнцүүлэн долоо хоноогоор хийж батлуулан мөрдөн ажиллаж байна.

Дотоодын цэргийн штабын даргын тушаалаар Улсын онц чухал объектын хамгаалалтыг 2 удаа хүч нэмэгдүүлэн зохион байгуулж, салааны алба хаагчид өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэн ажилласан. 2019 оны 1 дүгээр улиралд объектын хамгаалалтад зөрчил дутагдал гараагүй хамгаалалт хэвийн явагдсан.

2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд “Улсын онц чухал объект”-оор:

-Байнгын үнэмлэхээр нэвтэрсэн иргэн-655

-Гаднаас нэвтэрсэн иргэд-161

-Тээврийн хэрэгсэл-159

-Хяналтанд авсан хөдөлгөөн-502 нийт 1477 хөдөлгөөн, 2.3 тонн ачаа, 750 толгой бог, 40 толгой бод мал шалган нэвтрүүлж, дамжин өнгөрүүлж хяналт тавьж ажилласан.

### **Б/Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалтын талаар**

2019 оны 1 дүгээр улиралд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээврийн замд харгалзан хүргэх хамгаалалт зохицуулалтад ажиллаагүй.

### **В/Нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх талаар**

2019 оны 1 дүгээр улиралд нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлд ямар нэгэн ажил арга хэмжээнд оролцоогүй болно.

## **ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУСГАЙ САЛАА**